

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

---

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ХАЯГИЙН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

MNS ..... : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
УЛААНБААТАР  
2021 ОН

## ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Сайнбуян, доктор Б.Баяртунгалаг, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, С.Амаржаргал, З.Нямбаяр, нар хамтран гүйцэтгэв.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүн, мэргэшсэн инженер Ч.Болорчулуун редакц хийж, Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүн, Монгол Улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Газар зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Г.Гантулга шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)

Цахим хуудас: [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn)

[www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)

© СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

## АГУУЛГА

ОРШИЛ .....	1
1 Хамрах хүрээ .....	2
2 Норматив эшлэл.....	2
3 Нэр томъёо, тодорхойлолт.....	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт .....	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт .....	4
4 Техникийн шаардлага .....	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага .....	5
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага .....	6
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага.....	7
4.4 UML диаграмм (норматив).....	7
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага.....	7
A хавсралт - Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга .....	9
B хавсралт - Кодын жагсаалт.....	24
C хавсралт - UML диаграмм.....	28
D хавсралт - Өгөгдлийн чанар .....	32

## ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг эрхлэх байгууллага нөгөө талаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах орон зайн өгөгдлийн дэд бүтэц болох INSPIRE системийн баримт бичиг, ISO 19100 бүхий цуврал стандартуудын шаардлагад тулгуурлаж, Монгол улсын “Хаягжуулалтын тухай” хууль болон “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” зэрэг мөрдөж буй норм, дүрэм журам, хаягийн орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэн боловсруулав. Мөн хаягийн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх үүрэгтэй Нэгдмэл Загварчлалын Хэл (UML-Unified Modeling Language) загварчлалын дагуу боловсруулав.

Энэхүү стандарт нь хаягийн орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, орон зайн объектын төрөл, атрибут болон тэдгээрийн дүрслэлийг агуулсан UML диаграмм, техникийн шаардлагуудаас бүрдэнэ.

Уг стандарт нь хаягийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор хаягтай холбоотой өгөгдлийг системтэй, уялдаатай бүрдүүлэхэд чиглэнэ.

Хаягийн орон зайн өгөгдөлд хаягийн бүсийн нэр, хаягийн иж бүрдэл, хаягийн дүрслэл, хаяг чиглүүлэгч, засаг захиргааны нэгжийн нэр, гудамж, гудамжийн нэр, шуудангийн бүс, газар зүйн байршил, байршил заагчийн ангилал, байршлын нэр, ангилал, геометрийн аргазүйн ангилал, геометрийн зориулалтын ангилал, хэсэгчилсэн ангилал, статусын ангилал зэрэг хаягжуулалттай холбоотой мэдээллийг агуулна.

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... 2021
Geographic information. Data specification on address	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны ... дугаар сарын .....ний өдрийн ..... дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөгдөнө.

## 1 Хамрах хүрээ

Хаягийн орон зайн суурь өгөгдлийн сан нь “Хаягжуулалтын тухай” хууль, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-д заасан хаягийн иж бүрдэл, тэдгээрт хамрагдах шинж чанарын мэдээллийг агуулна.

Энэхүү стандарт нь хаягийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлно.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд хаягийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

## 2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

- ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл;*
- ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;*
- ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;*
- ISO 19108-с, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;*
- ISO 19109:2005, Газар зүйн мэдээлэл – Хэрэглээний схемийн дүрмүүд;*
- ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;*
- ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;*
- ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;*
- ISO/TS 19127:2005, Газар зүйн мэдээлэл – Геодезийн код ба параметрүүд;*
- ISO 19131:2007, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт;*
- ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;*

*ISO/DIS 19156, Газар зүйн мэдээлэл – Ажиглалт ба хэмжилт;*  
*ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;*  
*MNS 5774:2007 Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл*  
*MNS ISO/TS 19104:2012 Газар зүйн мэдээлэл - Нэр томьёо*

### **3 Нэр томьёо, тодорхойлолт**

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

#### **3.1**

#### **Үндсэн агуулгад хамаарах ойлголт**

##### **3.1.1**

##### **орон зайн өгөгдөл**

газрын гадарга дээрх болон газрын хэвлий, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц.

##### **3.1.2**

##### **орон зайн суурь өгөгдөл**

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл.

##### **3.1.3**

##### **өгөгдлийн багц**

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулгыг

##### **3.1.4**

##### **стерео төрөл**

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрлийг

##### **3.1.5**

##### **өгөгдөл төрөл**

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрлийг.

##### **3.1.6**

##### **биет төрөл**

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрлийг.

##### **3.1.7**

##### **кодын жагсаалт**

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутаг ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

### **3.1.8**

#### **домэйн**

тухайн сэдвийн үзүүлэлтийн агуулгын хүрээг илэрхийлэгч. Тухайлбал, хэмжээс /measure/ заасан утгын төрөлд “хэмжсэн тоон утга” л байх ёстой гэсэн шалгуур нь домэйн болохыг.

### **3.2**

#### **Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт**

### **3.2.1**

#### **Any**

Тухайн хувьсагч руу ямар ч утгыг шууд ашиглах боломжтойг зааж өгсөн төрлийг хэлнэ. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005-аас үзэж болно]

### **3.2.2**

#### **Character string**

Тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

### **3.2.3**

#### **Date time**

Цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

### **3.2.4**

#### **EX\_Extent**

Биетийн орон зайн, босоо түвшний байрлалын болон цаг хугацааны талаарх мэдээллийг [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

### **3.2.5**

#### **GM\_MultiSurface**

Олон гадаргуу бүхий геометр биетийг [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

### **3.2.6**

#### **Identifier**

Тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005]

### **3.2.7**


#### **TM\_Period**

Энэ нь цаг хугацааны цар хүрээг илэрхийлдэг нэг хэмжээст утга юм. Хугацааны утгыг түүний эхлэх ба дуусах түр зуурын утгаар дүрсэлдэг бөгөөд үүний үргэлжлэх хугацаа нь эдгээр хоёр түр зуурын утга хоорондын зайтай тэнцэхийг. [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO 19108:2002/Cor 1:2006]

## 4 Техникийн шаардлага

### 4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага

4.1.1 Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох **өгөгдлийн багц**, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй **“атрибут”**, атрибутанд орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан **“кодын жагсаалт”** гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.



1-р зураг – Хаягийн оронзайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

4.1.2 А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

4.1.3 В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.



**4.1.4** Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн “биет төрөл» /feature type/, “өгөгдөл төрөл» /data type/, “кодын жагсаалт» /code list/ гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

**4.1.5** Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

**4.1.6** Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

**4.1.7** Хаягийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **Хаяг** гэсэн 1 өгөгдлийн багцаас бүрдсэн байна.

**4.1.8** Хаягийн орон зайн өгөгдлийн санд 6 биет төрөл, 4 өгөгдөл төрөл агуулна.

## **4.2 Атрибурад тавигдах (норматив) шаардлага**

**4.2.1** Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

**4.2.2** Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

**4.2.3** Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /External id/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /Local id/, “нэрийн талбар” /Name space/, “танигчийн хувилбар” /Version id/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

**4.2.3.1 “Дотоод танигч /Local id/”** нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.

**4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/”** нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

**4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/”** нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

**4.2.4** Хаягийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 -д заасан “Газар зүйн нэр” /Geographical name/ орон зайн дэд өгөгдлийн сантай холбогдоно.

**4.2.4.1** “Газар зүйн нэр” /Geographical name/ нь тухайн хаягийн “Нэр” /Name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газар зүйн нэр» гэсэн

«өгөгдөл төрөл» ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газар зүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS .....:2021” стандартаас авч ашиглана.

### **4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага**

**4.3.1** А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

**4.3.2** Хаягийн орон зайн өгөгдлийн санд 7 кодын жагсаалт агуулна.

**4.3.3** А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

### **4.4 UML диаграмм (норматив)**

**4.4.1** Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

**4.4.2** Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

**4.4.3** С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна Хаягийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

### **4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага**

**4.5.1** Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь дэд бүтцийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.6-р хүснэгтэд үзүүлснээр дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

**4.5.2** Хаягийн орон зайн суурь өгөгдлийн сангийн өгөгдлийн багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь 4.5.3.1 - 4.5.3.4-д заасан өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлтийг хангана.

**4.5.2.1 Иж бүрдэл:** өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь биет болон тэдгээрийн атрибут, харилцан хамаарлуудын түвшин.

**4.5.2.2 Утга агуулгын нийцтэй байдал:** өгөгдлийн бүтэц, атрибут ба харилцан хамаарлуудын логик дүрмүүдийг баримтлах түвшин.

**4.5.2.3 Байршлын нарийвчлал:** орон зайн объектын байршлын нарийвчлалын түвшин.

**4.5.2.4 Сэдэвчилсэн нарийвчлал:** тоон атрибутуудын нарийвчлал ба тоон бус атрибутуудын бодит байдал болон биет, тэдгээрийн харилцан хамаарлын түвшин.

## **ТӨГСӨВ**

ТӨГСӨӨГ

## А Хавсралт

(норматив)

### Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

#### А.1-р хүснэгт – Хаягийн орон зайн суурь өгөгдлийн багц ба стерео төрлүүд

##### А.1.1 Өгөгдлийн багц: Хаяг (Addresses)

Д/д	Өгөгдлийн нэр	Стерео төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	<b>Хаяг</b> /Address/	«биет төрөл» «feature type»	Цэг, Шулуун, Полигон	Газар зүйн нэр болон танигчаас бүрдсэн үл хөдлөх хөрөнгийн байршлыг тогтоосон тодорхойлогч юм. /Орон зайн объектыг хаягаар лавлах болон бусад олон төрлийн хэрэглээнд ашигладаг. Жишээ нь тухайн барилгад амьдарч буй иргэдийн талаарх статистик гаргахад, барилгад байрлаж буй аж ахуйн нэгжүүдэд татвар ноогдуулахад, тоног төхөөрөмж суурилуулахад мөн үл хөдлөх хөрөнгийг лавлахад энэ нь эзэмшил газар, байшин барилга, нэвтрэх орц, гарц, бусад байгууламж гэх мэт хамаарна/.
2	<b>Хаягийн талбайн нэр</b> /Address area name/	«биет төрөл» «feature type»	Полигон	Газар зүйн бүс нутаг эсвэл орон нутгийн хаяглагддаг объектуудыг засаг захиргааны нэгжид хамааруулахгүйгээр хаяглах зорилгоор бүлэглэсэн нэрийг илэрхийлэх хаягийн бүрэлдэхүүн хэсэг юм. /Хаягийн талбайн нэрийн зорилго нь тухайн хаягийг илүү тодорхой мэдээлэлтэй, тайлбартай байх боломжийг олгох бөгөөд тухайн хаягт газрын нэрийг (жишээ нь тосгон эсвэл багийн гэх мэт) нэмж оруулах мөн хот эсвэл шуудангийн код нь том газар нутгийг хамарч буй тохиолдолд илүү ашигтай байдаг/.
3	<b>Хаягийн иж бүрдэл</b> /Address component/	«биет төрөл» «feature type»	Цэг, Шулуун, Полигон	Газар зүйн бүс, байршил болон бусад орон зайн объектын танигч эсвэл Газар зүйн нэрээр хаягийн хамрах хүрээг тодорхойлно. /Хаягийн иж бүрдэл нь засаг захиргааны нэр, хаягийн талбайн нэр, зорчих гудамжны нэр, шуудангийн код гэх мэтээр ихэвчлэн шаталсан байдлаар бүтэцлэгддэг. Энэ нь хаягийг хүн уншихад хялбар, хоёрдмол утгагүй болгодог/.

4	<b>Засаг захиргааны нэгжийн нэр</b> <i>/Admin unit name/</i>	«биет төрөл» <i>/feature type»</i>	Полигон	Улс, орон нутаг, бүс нутаг, үндэсний хэмжээнд засаг захиргааны нэгжийн нэрийг илэрхийлсэн хаягийн бүрэлдэхүүн хэсэг.
5	<b>Шуудангийн бүс</b> <i>/Postal descriptor/</i>	«биет төрөл» <i>«feature type»</i>	Полигон	Шуудангийн зорилгоор улс, бүс нутаг эсвэл хот дахь хаягийн хуваалт болон шуудан хүргэлтийн цэгүүдийг таних хаягийн бүрэлдэхүүн хэсэг. /Шуудангийн бүсийг шуудан үйлчилгээний шаардлагын дагуу (жишээ нь үр ашигтай ангилах, логистик, тээвэрлэлт, түгээлт хийхэд) үүсгэж бий болгох мөн шуудангийн код нь газарзүй бүс нутаг, хотын нэр эсвэл холбогдох шуудангийн салбараар ч тодорхойлогдож болно/.
6	<b>Гудамж</b> <i>/Thoroughfare name/</i>	«биет төрөл» <i>«feature type»</i>	Шулуун	Нэг байршлаас нөгөө байршил руу хүргэдэг эсвэл дамжин өнгөрөх хэсэг буюу гудамжийг /өргөн чөлөө/ илэрхийлдэг хаягийн бүрдэл хэсэг. /Авто зам, усан зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн, жижиг тосгон, суурингийн замын сүлжээг багтааж болно/.
7	<b>Хаяг чиглүүлэгч</b> <i>/Address locator/</i>	«өгөгдөл төрөл» <i>«data type»</i>	-	Хаяг чиглүүлэгч нь хэрэглэгч эсвэл программ тухайн хаяг руу хандах үед гудамж, өргөн чөлөөний нэр, хаягийн бүсийн нэр, засаг захиргааны нэгжийн нэр, шуудан тодорхойлогчийн хүрээнд зэргэлдээ хаягаас ялгах, лавлах боломжийг олгодог хүн уншихад тодорхой нэрийг илэрхийлнэ. /Эдгээр нэр нь хоорондоо давхардахгүйгээр үл хөдлөх, барилга байгууламж, байшин орон сууц, давхрын дугаар, өрөөний дугаар гэх мэт шаталсан хэлбэрээр зохиогдож болно/.
8	<b>Хаягийн дүрслэл</b> <i>/Address representation/</i>	«өгөгдөл төрөл» <i>«data type»</i>	-	Хаягийн суурь мэдээллийг уншихад хялбар байдлаар оруулах шаардлагатай гадаад өгөгдлийн бүтцэд ашиглагдах орон зайн объектын хаягийн дүрслэл. Өгөгдлийн төрөл нь уншигдах шаардлагатай бүх хаягийн бүрэлдэхүүн хэсгийг багтаахаас гадна (улс, бүс, хот, хаягийн бүс, шуудангийн код, гудамжны нэр, хаягийн дугаар г.м) хаягийн орон зайн объектыг танихад тусална.
9	<b>Газар зүйн байршил</b> <i>/Geographic position/</i>	«өгөгдөл төрөл» <i>«data type»</i>	-	Байршлын анхдагч мэдээллийг багтаасан тодорхой үзүүлэлтийн дагуу хаягийн байршлыг илэрхийлэх шинж чанар бүхий цэгийн байршил.
10	<b>Гудамжны нэр</b> <i>/Thoroughfare name value/</i>	«өгөгдөл төрөл» <i>«data type»</i>	-	Энэ өгөгдлийн төрөл нь нэрийг өөр өөр хэл, бичгээр оруулах, нэмэлт өөр нэр өгөх, ялгаатай дуудлага оруулах, түүхэн нэр болон эксоним нэрийг оруулах боломжийг олгодог нэрийн хэсэг бүрийг багтаасан гудамж, өргөн чөлөөнд оноосон нэр юм. Мөн гудамжны нэрийг салангид, семантик хэсгүүдэд хувааж илэрхийлэх боломжийг олгодог.

11	<b>Геометрийн аргагүйн ангилал</b> <i>/Geometry method value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Хаягийн Газар зүйн байрлалыг хэн хэрхэн үүсгэсэн тухай тайлбар /Ямар төрлийн орон зайн функцээр хаягийн Газар зүйн байрлалыг үүсгэсэн эсвэл олж авсан талаар мэдээлэл нь Geometry specification value-р илэрхийлэгдэнэ/.
12	<b>Геометрийн зориулалтын ангилал</b> <i>/Geometry specification value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Тухайн хаягийн Газар зүйн байрлалыг үүсгэх, олж авахад ашигласан техникийн тодорхойлолтыг тайлбарласан мэдээлэл багтана /Нэг орон зайн объект /полигон/-оос олон тооны хаягийн цэгүүдийг авах боломжтой мөн хаяг бүрд ижил цэг хэрэглэгдвэл хаягууд давхцаж болно/.
13	<b>Байршил заагчийн ангилал</b> <i>/Locator designator type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Байршил заагчийн төрөл, тэдгээрийн тайлбар.
14	<b>Байршлын нэр, ангилал</b> <i>/Locator name type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Байршил заагчийн нэрийн төрөл, тэдгээрийн тайлбар.
15	<b>Гудамжны нэрийн бүрдэл хэсгийн ангилал</b> <i>/Part type value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Гудамж, өргөн чөлөөний нэрийн бүрдэл хэсгүүдийн ангилал.
16	<b>Статусын ангилал</b> <i>/Status value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Хаяг, хаягийн бүрдэл хэсэг нь бодит ертөнц дээр одоогийн байдлаарх хүчин төгөлдөр байгаа эсэхийг илэрхийлнэ. /Энэ нь хэрэглээн дэх хаяг, хаягийн бүрдэл хэсгийн оршин тогтнох хугацаа буюу санал болгосон, нөөцөлсөн, хадгалсан, одоогийн байдлаар хүчинтэй эсвэл хүчингүй, нэмэлт хувилбар, одоо ашиглаж байгаа зэрэг хувилбараар ашиглах боломжийг олгодог/.
17	<b>Байршуулагчийн зааж буй түвшин</b> <i>/Locator level value/</i>	«кодын жагсаалт» <i>/code list/</i>	Ангилал	Байршуулагчийн зааж буй түвшний ангилал.

## А.2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

### А.2.1 Өгөгдлийн багц – Хаягууд (Addresses)

#### А.2.1.1 Биет төрлийн нэр: Хаяг (Address)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Сонгосон солбицлын тогтолцоон дах координатаар илэрхийлсэн цэг, шулуун, талбайн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр. Дотоод танигчид зориулсан хамрах хүрээний үзүүлэлт.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Нэмэлт дотоод танигч</b> /Alternative identifier/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Орон зайн объектын хаягийн бүрэлдэхүүн хэсгийн нэмэлт сэдэвчилсэн тодорхойлогч. Бусад систем болон програмуудтай харилцан ажиллах боломжийг олгодог. /Хаягийн бүрдэл хэсгийн тодорхойлогчтой харьцуулахад нэмэлт танигч нь орон зайн объектын оршин тогтнох хугацаанд тогтвортой байх шаардлагагүй бөгөөд ихэвчлэн орон зайн объектын хувилбарын талаарх мэдээллийг агуулдаг.
6	<b>Мэдээлэл бүртгэсэн хугацаа</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо, цаг.
7	<b>Мэдээлэл шинэчилсэн, устгасан хугацаа</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад орлуулсан эсвэл цуцалсан огноо, цаг.

8	<b>Хүчинтэй хугацаа</b> /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хаяг нь бодит ертөнцөд хүчин төгөлдөр болсон эсвэл болох огноо ба цаг.
9	<b>Хүчингүй болох хугацаа</b> /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хаяг нь бодит ертөнцөд хүчингүй болсон эсвэл хүчингүй болох огноо, цаг.
10	<b>Байршил</b> /Position/	«Газар зүйн байрлал» «Geographic position»	-	-	Тухайн байршлын анхдагч мэдээллийг багтаасан тусгай тодорхойлолтын дагуу хаягийн байршлыг илэрхийлдэг онцлог цэгийн Газар зүйн байршил.
11	<b>Статус</b> /Status/	<b>Статусын ангилал</b> /Status value/	-	-	Хаяг, хаягийн бүрдэл хэсгийн оршин байгаа одоогийн хүчин төгөлдөр байдал. /Энэ нь хэрэглээн дэх хаяг, хаягийн бүрдэл хэсгийн оршин тогтнох хугацаа буюу санал болгосон, нөөцөлсөн, хадгалсан, одоогийн байдлаар хүчинтэй эсвэл хүчингүй, нэмэлт хувилбар, одоо ашиглаж байгаа зэрэг хувилбараар ашиглах боломжийг олгодог/. StatusValue - харгалзах кодын жагсаалтыг ашиглана.
12	<b>Хаяг байршуулагч</b> /Locator/	«Хаяг байршуулагч» «Address locator»	-	-	Хүн унших боломжтой хаягийн байршил эсвэл нэр.

#### A.2.1.2 Өгөгдөл төрлийн нэр: Хаяг байршуулагч (Address locator)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Байршлын нэр</b> /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Байршлын нэрийг тодорхойлж буй хэсэг. /Өгөгдлийн төрөл нь нэрийг өөр хэл, бичгээр оруулах, нэмэлт нэр, ялгаатай дуудлага, түүхэн нэр, эксоним оруулах боломжийг олгодог мөн байршлын нэр нь заримдаа тухайн үл хөдлөх, барилга байшинг эзэмшдэг, эсвэл эзэмшиж байсан гэр бүл, аж ахуйн нэгжийн нэр байж болдог/. Газар зүйн нэр орон зайн дэд өгөгдлийн сангийн стандартын Газар зүйн нэр /Geographical name/ өгөгдөл төрлийг ашиглана.
2	<b>Байршлын нэрийн төрөл</b> /Locator name type/	<b>Байршлын нэрийн ангилал</b> /Locator name type value/	-	-	Программд тодорхой дүрмийн дагуу хөрвүүлэх, задлах, форматлах боломж олгодог хайгчийн утгын төрөл. /Энэ төрөл нь хэрэглэгч болон программд "Radford Mill Farm" гэдэг нэр жишээлбэл тодорхой газар эсвэл байшингийн



					нэр үү гэдгийг ойлгох боломжийг олгодог/. LocatorNameTypeValue – кодын жагсаалтаас авна.
3	<b>Заагч</b> /Designator/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	40	Байршил заагчийн гол тодорхойлогч нь нэг буюу хэд хэдэн тоо болон тэмдэгтээс бүрдсэн байна. /Утга нь ихэвчлэн бүгдийн сайн мэддэг дүрмийн дагуу олгогдсон тайлбарласан код юм, жишээ нь гудамжны дагуух өгссөн тэгш сондгой хаягийн дугаар, давхрын таних тэмдэг болох 0, 1, 2, 3 гэх мэт/.
4	<b>Байршил заагчийн төрөл</b> /Locator designator type/	<b>Байршил заагчийн ангилал</b> /Locator designator type value/	-	-	Программд тодорхой дүрмийн дагуу хөрвүүлэх, задлах, форматлах боломж олгодог хайгч заагчийн утгын төрөл. /Төрөл нь хэрэглэгчид болон программд "А" утга юуны таних тэмдэг (жишээ нь: барилгын, хаалганы, давхрын г.м) болохыг ойлгох боломжийг олгодог/. Locator designator type value – кодын жагсаалтаас авна.
5	<b>Заагчийн түвшин</b> /Level/	<b>Байршлын зааж буй түвшин</b> /Locator level value/	-	-	Байршуулагчийн зааж буй түвшний ангилал.

### А.2.1.3 Өгөгдөл төрлийн нэр: Газар зүйн байршил (Geographic position)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Цэг /GM_Point/	-	-	Сонгосон солбицлын тогтолцоон дах координатаар илэрхийлсэн цэгэн байрлал.
2	<b>Газар зүйн байршлын үзүүлэлт</b> /Specification/	<b>Геометр дүрслэлийн ангилал</b> /Geometry specification value/	-	-	Хаягийн Газар зүйн байрлалыг үүсгэх эсвэл олж авахад ашигладаг үзүүлэлтийг тодорхойлдог мэдээлэл. Geometry specification value – кодын жагсаалтаас авна.
3	<b>Аргазүй</b> /Method/	<b>Бүртгэх аргазүйн ангилал</b> /Geometry method value/	-	-	Хаягийн Газар зүйн байрлалыг хэн хэрхэн үүсгэсэн эсвэл гаргаж авсан тухай тайлбар. /Газар зүйн байрлалыг хаяг удирддаг эрх бүхий байгууллага, мэргэжилтэн өөрөө гар аргаар үүсгэх эсвэл бие даасан байгууллага (жишээ нь хээрийн судалгаа хийж эсвэл цаасан дээрх газрын зургийг дижиталчлах замаар), болон хаяглагддаг объектоос эсвэл бусад функцээс

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
					автоматаар үүсгэх боломжтой/. Geometry method value – кодын жагсаалтаас авна.
4	<b>Өгөгдмөл</b> /Default/	Логик /Boolean/	Логик /Boolean/	5	Тухайн байрлалыг үндсэн гэж үзэх эсэхийг тодорхойлно. /Хамгийн сайн нарийвчлалтай байрлалыг үндсэн гэж үзэх нь зүйтэй/.

#### А.2.1.4 Биет төрлийн нэр: Хаягийн бүсийн нэр (Address area name)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Дотоод танигч</b> /Local id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
2	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр. Дотоод танигчид зориулсан хамрах хүрээний үзүүлэлт.
3	<b>Танигчийн хувилбар</b> /Version id/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
4	<b>Нэмэлт дотоод танигч</b> /Alternative identifier/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Орон зайн объектын хаягийн бүрэлдэхүүн хэсгийн нэмэлт сэдэвчилсэн тодорхойлогч. Бусад систем болон програмуудтай харилцан ажиллах боломжийг олгодог. /Хаягийн бүрдэл хэсгийн тодорхойлогчтой харьцуулахад нэмэлт танигч нь орон зайн объектын оршин тогтнох хугацаанд тогтвортой байх шаардлагагүй бөгөөд ихэвчлэн орон зайн объектын хувилбарын талаарх мэдээллийг агуулдаг.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн хугацаа</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын тухайн хувилбарыг орон зайн дата багцад оруулсан эсвэл өөрчлөлт хийсэн огноо, цаг.

6	<b>Мэдээлэл шинэчилсэн, устгасан хугацаа</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын тухайн хувилбарыг орон зайн мэдээллийн багцаас цуцалсан эсвэл чөлөөлсөн огноо, цаг.
7	<b>Хүчинтэй хугацаа</b> /Valid from/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хаягийн бүрэлдэхүүн хэсгийн бодит ертөнцөд хүчин төгөлдөр болсон эсвэл болох огноо ба цаг.
8	<b>Хүчингүй болох хугацаа</b> /Valid to/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Хаягийн бүрэлдэхүүн хэсгийн бодит ертөнцөд хүчингүй болсон эсвэл хүчингүй болох огноо, цаг.
9	<b>Хаягийн бүсэд оноосон Газар зүйн нэр</b> /Name/	«Газар зүйн нэр» «Geographical name»	-	-	Өгөгдлийн төрөл нь нэмэлт нэр, өөр дуудлага, түүхэн нэр болон эксоним нэрийг оруулах боломжийг олгоно. Газар зүйн нэр орон зайн дэд өгөгдлийн сангийн стандартын Газар зүйн нэр /Geographical name/ өгөгдөл төрлийг ашиглана.
